

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ  
3 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2017.04.03

**Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл 03 дугаар сарын 15-ны өдөр хуралдаж, 2016 онд тус аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, зарим төрлийн гэмт хэргийн үйлдэгдсэн шалтгаан нөхцөл, цаашид анхаарч хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаар Цагдаагийн газрын дарга, төрийн албан хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг болон албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан нөхцөл, цаашид анхаарах асуудлуудын талаар аймгийн ерөнхий прокурорын мэдээллүүдийг хэлэлцэн Аймгийн ГХУСАЗЗ-өөс 2017 онд зохион байгуулж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, сумдын ГХУСАЗЗ-үүдийн үйл ажиллагааг шалган туслах ажлын удирдамж, хуваарийг хэлэлцэн баталлаа.

Тулгар төрийн 2226 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 811 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 106 жил, Ардын хувьсгалын 96 жил, Монгол цэргийн өдөр-Зэвсэгт хүчний 96 жилийн ой, Казах түмний Наурызын баяр болон Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар зарлигаар аж үйлдвэр, хууль эрх зүй, эрүүл мэнд, эдийн засаг, боловсрол, соёл, спорт, харилцаа холбоо, худалдаа үйлчилгээ, мал аж ахуй, газар тариалан болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан Сэлэнгэ аймгийн харъяат 58 иргэнийг Монгол Улсын одон, медалиар шагнасныг гардуулан өгөх арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 4, Цэргийн гавьяаны одонгоор 3, Алтан гадас одонгоор 17, Цэргийн хүндэт медалиар 6, Хөдөлмөрийн хүндэт медалиар 27 иргэн шагнагдсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар сумдын ИТХ-ын Тэргүүлэгчид, түүний ажлын албаны 2017 оны төлөвлөгөө, хэрэгжилтийн явц байдалтай танилцлаа. Шалган танилцах үзлэгийн үеэр сумдын ИТХ-ын дарга, Нарийн бичгийн дарга нарын боловсруулан гаргадаг баримт бичгийн эмх цэгц, хурлаас батлан гаргасан аливаа шийдвэрүүдийн хэрэгжилтэд анхаарал хандуулах, хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, төлөөлөгчдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг зөвлөлөө.

**2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

“Иргэдээ сонсьё” телевизийн шууд нэвтрүүлгийг энэ сарын 31-ний өдөр өргөтгөсөн байдлаар зохион байгуулж, аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ЗДТГ-ын дарга болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын дарга, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын удирдлагууд оролцлоо. Нэвтрүүлгийн үеэр зам талбайн гэрэлтүүлэг, хог хаягдал, тохижилт бүтээн байгуулалт, халаалт дулаан гэх мэт бүхий л төрлийн асуудлуудаар санал бодлоо илэрхийлж, асуулт асууж хариулт авлаа. Нэвтрүүлгийн эхэнд аймгийн Засаг дарга иргэдийн цахимаар ирсэн асуултад хариулж, нэвтрүүлгийн төгсгөлд агентлагуудад үүрэг чиглэл өглөө.

“Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа” сургалт хэлэлцүүлгийг Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоо, аймгийн Засаг даргын Тамгын газар бусад холбогдох газрууд хамтран зохион байгуулж, аймаг, сумдын Засаг дарга, сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч, аймгийн зарим газар, хэлтсийн дарга нарт сүрьеэ өвчний талаар мэдээлэл өгч, цаашид эх, хүүхдийн эрүүл мэндийн асуудал, Сүрьеэгийн өвчлөлийг бууруулах цаашлаад таслан зогсоох, БЗДХ-ын асуудлуудтай

холбогдон гарсан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудтай уялдаа холбоотой хамтран ажиллах талаар чиглэл өгсөн.

“Монгол цэргийн өдөр”-ийг угтан аймгийн цэргийн болон цэрэгжүүлсэн байгууллагуудын албан хаагчдын дунд зохион байгуулсан үндэсний шагайн харваа, “Мөрдөстэй бүсгүйчүүд”, МУ-ын буудлагын спортын мастер, бэлтгэл дэд хурандаа Д.Ганбаатарын нэрэмжит “Мэргэн буудлага”, сагс, Волейбол, Ширээний теннис, “Би эр хүн” 20 км-ийн кросс гүйлт, “Тэргүүний дууч, жагсаалч салаа”, “Марш тактикийн тусгай бэлтгэлийн аварга тасаг” зэрэг нийт 9 төрлийн тэмцээнүүдээр 03-р сарын 06-наас 16-ны өдрийг хүртэл явагдаж аваргуудаа тодруулсан.Тэмцээний 6 төрөлд хурандаа Х.Дамдинсүрэн захирагчтай Хилийн 0243-р анги тэргүүлж,багийн дүнгээр 1-р байр эзлэн цом, мөнгөн шагналаар шагнагдлаа.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн хүрээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, цаашдын зорилт” сэдэвт сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Монголын Ажил олгогч эздийн холбоотой хамтран 3-р сарын 24–ний өдөр Сүхбаатар суманд зохион байгууллаа. Сургалтаар үндэсний 4 дэх хөтөлбөрийн хэрэгжилт, 5 дахь төсөлд санал авах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдээллийг хийж, Булган, Дархан-Уул, Орхон аймгуудын холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцлоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын болон орон нутгийн төр, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд ISO 9001:2015 стандарт буюу Чанарын менежментийн системийг нэвтрүүлэх тухай сургалтыг зохион байгуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын нийт ажилтнууд, зарим сумдын Засаг даргын Тамгын газар, агентлагийн холбогдох албан тушаалтнуудыг оролцууллаа.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн REACH төсөл хамтран “Жижиг, дунд бизнесүүдийн зээлжилтийг дэмжих форум-2017” уулзалтыг 17 сумын жижиг дунд бизнес эрхлэгчдийн төлөөллийг оролцуулан жижиг, дунд бизнесийн зээлжих чадавхийг сайжруулахад шаардлагатай арга замуудыг оролцогч талуудын түншлэл, хамтын ажиллагааны үр дүнд бий болгох зорилгын дор 3-р сарын 28–ны өдөр Сүхбаатар суманд зохион байгууллаа.

### **Онцгой байдлын талаар:**

Онцгой байдлын ерөнхий газрын даргын “Үүрэг хүргүүлэх тухай” 2017 оны 1/492 тоот албан үүргийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх 7 хоногийн Лхагва гарагийг “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болгох тухай, 2011 оны 339 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд өгөгдсөн үүргийг хэрэгжүүлж, үүргийн биелэлтийг ОБЕГ-т цахимаар болон цаасаар хүргүүлсэн.

“Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм”, “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагааны нэгдсэн заавар” болон бусад стандарт, техникийн норматив, дүрэм, журам зэрэг эрх зүйн баримт бичгийг үндэслэн Сүхбаатар, Сайхан, Баянгол, Мандал суманд үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын байгууллагын судалгааг гарган нийт 25 сургууль, цэцэрлэгт хяналт шалгалтыг хийж 63 зөрчлийг илрүүлж, үзлэг шалгалтын явцад 11 зөрчлийг барагдуулж, бусад зөрчлийг арилгуулахаар улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 20, мэдэгдэл 5 бичиж хүргүүлэн байгууллагын дарга /захирал/ нарт гардуулан ажилласан.

### **Хяналт шалгалтын ажлын харьцуулалт**

Үзүүлэлт	Үзлэг шалгалтанд хамрагдсан	Зөрчил	Бичсэн эрх зүйн бичиг баримт	Хянасан зураг төсөл
----------	-----------------------------	--------	------------------------------	---------------------

Он	ААНБ	Айл өрх	Илрүүлсэн	Арилгуулсан	ЗБАШ	Мөдөгдөл	Танилцуулга	Дүгнэлт	Акт	АЗТогоол	
2016 оны 03-р сар	61	-	179	69	44	17	-	2	3	1	1
2017 оны 03-р сар	50	-	89	27	23	27	1	1	3	-	4
Өссөн Буурсан /хувиар/	18	-	50.2	39.3	47	+62.3	100	50	-	50	+100

2017 оны 03 дугаар сард 2.2 сая төгрөгийн хохиролтой 7 удаагийн объектын гал түймэр гарсанаас 7 гал түймэр дээр гал түймэр унтраах, аврах анги ажиллан унтраасан бөгөөд гал түймрийн хэргийг Цагдаагийн байгууллагатай хамтран шалгаж, гал түймэр гарсан тухай акт 3-ийг үйлдэж, 4 гал түймрийн хэрэг мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байна. Гал түймрийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цахилгааны техникийн гэмтлээс 2, лаа, дэн, тамхи, чүдэнзний галаас 2, машин техникийн гэмтэл ашиглалтын буруугаас 1 шалтгаан тогтоогдоогүй 2 удаа тохиолдсон.

Аймгийн Онцгой комиссын хуралдааныг зохион байгуулж, уг хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/97 дугаар захирамжаар өвөлжилт хүндэрсэн Цагааннуур, Зүүнбүрэн, Алтанбулаг сумдад 5623400 төгрөгийн, аймгийн өвс тэжээлийн аюулгүй нөөцийг сумдад хуваарилах шатахууны зардалд 2778104 төгрөг нийт 8401504 төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлсэн.

Шар усны үерээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрэн хайх, аврах ангийн хариуцсан Сүхбаатар сумын 1, 2, 3, 6 дугаар багийн үерийн хамгаалалтын далан, суваг, шуудуунд үзлэг шалгалт хийж, хамгаалалтын даланг сэргээх, суваг шуудууг цэвэрлэх ажлыг зохион байгуулахыг холбогдох сум, багийн засаг дарга нарт албан бичгээр хүргүүлсэн.

#### **Мэргэжлийн хяналтын ажил үйлчилгээний талаар:**

2017 оны 3 дугаар сарыг “Хамтарсан зөвлөгөөн хийх, Сэлэнгийн бүсийн эрсдэлийг тодорхойлох сар” болгон 13 багц ажлыг төлөвлөн “Хамтын ажиллагаа, сахилга, хариуцлага” сэдэвт зөвлөгөөнийг 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдөр аймгийн ХХААГ-тай хамтран зохион байгуулж сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагчид, ХАА-н тасгийн мэргэжилтнүүд зэрэг 150 гаруй албан тушаалтнуудыг оролцуулан хүнсний аюулгүй байдал, хүрээлэн буй орчны аюулгүй байдлын талаар зөвлөлдөн, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар сум, Дулаанхаан тосгон буюу аймгийн бүсчлэлээр Сэлэнгийн бүсийн сумдад улсын байцаагчдын нэгдсэн хяналт шалгалтыг хийж, нийт 217 аж ахуйн нэгж, байгууллага, 239 иргэдийг хамруулан 717 зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчдын 53 албан шаардлага, 27 зөвлөмжийг үйлдэн, 4968.0 мянган төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулж ажилласан.

#### **Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:**

Тайлант сард Сүхбаатар, Орхонтуул, Ерөө сумдын 3 аж ахуйн нэгжийн 5 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж, Орхонтуул сумын “Замбал зоог” ХХК-ий бууз банш, Сүхбаатар сумын “Эрчин” ХХК-ий цуунд даршилсан байцааны хаяг шошгыг холбогдох

стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлүүлж, сорилт шинжилгээнд хамруулсан. Мөн стандартын салбар сангаас 3 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 4 нэрийн 4 стандартаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгсөн.

“Хэмжих хэрэгсэл шалгалт, тохируулгад хамруулах 2017 оны гэрээ, график” байгуулж, хэмжүүр баталгаажуулалтанд ашиглагддаг 4 эталон хэмжүүрийг шалгалт, тохируулгад хамруулж, механик хэмжлийн ээлжит баталгаажуулалтаар Сүхбаатар суманд ажиллаж, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, эмнэлэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа 18 жинг баталгаажуулалтад хамруулж, Сүхбаатар сумын “НИК” ШТС-ийн хүсэлтийн дагуу 1 түгээгүүрийн шахалтыг шалгаж, тохируулга хийн 4 аж ахуйн нэгжийн цусны даралтын аппаратыг шалган, 3 аппаратыг баталгаажуулж, 1 аж ахуйн нэгжид ашиглахгүй байх мэдэгдэл өгч, 2 лабораторийн жинд шалгалт тохируулга хийсэн.

Цахилгааны хэмжлийн лабораториос Сүхбаатар сумын иргэд, хэрэглэгч аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 1 фазын 9 ш цахилгааны тоолуурыг ээлжит баталгаажуулалтанд хамруулж, цахилгааны тоолуур гацсан талаарх 4 гомдлыг хүлээн авч, барагдуулсан.

Мөн Алтанбулаг сумын 1 хүнсний дэлгүүрт стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, гэрчилгээ олгож, аймгийн Авто тээврийн газраас авто үйлчилгээ эрхлэгчидтэй хийсэн уулзалтанд холбогдох стандартын шаардлага болон тохирлын үнэлгээний талаар мэдээлэл өгсөн.

### **Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн тайланг гаргах талаар Сангийн яамнаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу 17 сум, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас тайланг хүлээн авч, нэгтгэн ажиллаж байна.

Хөрөнгийн зах зээлийн нээлттэй холбоотой хамтран Сэлэнгэ аймагт анх удаа “Хөрөнгийн зах зээлийн суурь мэдлэг” сэдэвт төлбөртэй сургалтыг зохион байгуулж, сургалтанд нийт 40 хүн оролцсон бөгөөд Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга, нягтлан бодогч нар мөн төсвийн байгууллагын нягтлан бодогч, сумдын Санхүүгийн албаны дарга нар хамрагдсан.

Тайлант сард аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 853 баримтаар 2'293'321'409 төгрөгийн гүйлгээ хийж, орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүжилтийг олгосон.

2016 оны жилийн эцсийн орон нутгийн өмчийн тайлан нэгтгэж Өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. Тайлангаар аймгийн хэмжээнд нийт 148.6 тэрбум төгрөгийн барилга байгууламж, 14.3 тэрбум төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 6.2 тэрбум төгрөгийн тээврийн хэрэгсэл, 6.1 тэрбум төгрөгийн тавилга, эд хогшил, 2.0 тэрбум төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйлс, 919,1 сая төгрөгийн номын фонд, 3.5 тэрбум төгрөгийн дуусаагүй барилга, 15.2 тэрбум төгрөгийн бусад хөрөнгө бүртгэгдсэн байна.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны 2-р сарын танилцуулгыг боловсруулан гаргаж, аймгийн удирдлагуудад, 17 сум, 24 хэлтэс агентлагуудад хүргүүлж, танилцуулгыг [www.selenge.nso.mn](http://www.selenge.nso.mn) хуудсаар цахим хэлбэрээр мэдээлсэн.

#### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

<b>Д/д</b>	<b>Үзүүлэлтүүд</b>	<b>Төлөвлөгөө</b>	<b>Гүйцэтгэл</b>	<b>Хувь</b>
<b>1</b>	Орон нутгийн төсвийн нийт орлого	1,631,075.8	2,541,317.6	155.8
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	993,117.7	988,869.0	99.6
<b>2</b>	Орон нутгийн төсвийн нийт зарлага	11,893,621.0	10,303,432.1	86.6

	Үүнээс: ТЗШ байгууллагын зарлага	7,673,939.7	7,016,801.6	91.4
	- Аймгийн төсвийн зарлагын дүн	2,191,216.6	1,876,617.0	85.6
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	46,211.5	21,061.2	45.6
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	80,000.0	80,000.0	100.0
	-Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	-	-	-
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	178,533.9	178,533.9	100.0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	800,000.0	800,000.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	7,840,750.3	7,840,750.3	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	3,810,874.3	3,810,874.3	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	2,073,005.2	2,073,005.2	100.0
	- Соёлын байгууллага	573,707.4	573,707.4	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	228,831.1	228,831.1	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	1,044,118.4	1,044,118.4	100.0
	- Хүүхдийн байгууллага	38,996.7	38,996.7	100.0
	- Газрын харилцааны байгууллага	71,217.2	71,217.2	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	7,840,750.3	7,840,750.3	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	3,810,874.3	3,810,874.3	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	2,073,005.2	2,073,005.2	100.0
	- Соёлын байгууллага	573,707.4	573,707.4	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	228,831.1	228,831.1	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	1,044,118.4	1,044,118.4	100.0
	- Хүүхдийн байгууллага	38,996.7	38,996.7	100.0
	- Газрынхарилцааныбайгууллага	71,217.2	71,217.2	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	567,634.6	567,634.6	100.0
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	132,322.7	132,322.7	100.0
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	102,380.2	101,190.1	98.8
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	97,800.0	96,417.0	98.6
11	Тусгай сангуудын зарлага	-	-	-

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөнхэрэглээнийбараанынэртөрөл		2017 I - сар	2017 II - сар	<u>2017-II</u> <u>2017-I</u> /төгрөгөөр/
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	<b>ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>			
	Гурил /савласан, кг/	1200	1250	+50

	Талх /ороннутгийн, ш/	1100	1100	
	Нарийн боов /кг/	2000	2300	+300
	Будаа /кг/	2400	2400	
	Элсэн чихэр /кг/	2200	2200	
<b>2</b>	<b>МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хониныхмах /кг/	5000	5500	+500
	Үхрийн мах /кг/	6500	6800	+300
	Адууны мах /кг/	5500	6000	+500
	Ямааны мах /кг/	4000	5000	+1000
	Дотор мах, цувдай /цусгүй/	3000	5000	+2000
	Хиам /чанасан, кг/	10000	10000	
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	1500	1800	+300
	Сүү / савласан, л/	2500	2500	
	Тараг /задгай, л/	1800	1800	
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	12000	13000	+1000
	Айраг /л/	3500	3500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	
	Өндөг /ш/	320	320	
<b>4</b>	<b>БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
	Ургамлын тос /л/	3400	3500	+100
	Өөхөн тос /кг/	1800	1800	
	Шар тос /кг/	10000	10000	
	Масло /задгай, кг/	4000	4000	
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	600	600	
	Лууван /кг/	600	500	-100
	Манжин /кг/	1000	1000	
	Байцаа /кг/	1500	2000	+500
	Сонгино /кг/	1500	2500	+1000
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3200	3200	
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2200	2500	+300
<b>7</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1450	1480	+30
	Бензин А - 92	1530	1630	+100
	Дизелийн түлш	1690	1720	+30

### Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

#### **1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:**

Төрийн болон албаны нууцын тухай хуулийг төрийн албан хаагчдад мэдээллэх ажлыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын Тамгын газарт хамаарах нууцын мэдээллийн жагсаалтыг гаргаж Тагнуулын ерөнхий газарт, аймгийн терроризмтой тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөөг баталж Монгол Улсын Терроризмтой тэмцэх зөвлөлд тус тус хүргүүлж, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар буюу Нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нарт зориулсан сургалтыг энэ сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Мөн Авлигатай тэмцэх газрын Сэлэнгэ аймаг хариуцсан мэргэжилтэн тус аймагт 9-10-ны өдрүүдэд ажиллаж, Авлига, хүний эрхийн асуудал хариуцсан мэргэжилтний ажлыг шалгаж, мэдүүлэг гаргагч 2 албан тушаалтны мэдүүлэг гаргасан байдалтай газар дээр нь танилцаж арга зүйн зөвлөгөө өглөө.

Аймгийн хэмжээнд 2017 оны 2 дугаар сарын байдлаар нийт 129 холбогдогчтой, 250.0 сая төгрөгийн хохиролтой, 118 гэмт хэрэг бүртгэгдэж, 15 хэргээр буюу 11.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн гаралт Сүхбаатар сумын 7-р баг, Алтанбулаг, Баянгол сумдад 13.3-33,3 хувиар, Сүхбаатар сумын 1, 3, 6-р баг, Бугант тосгон, Хүдэр, Орхон сумдад 2-3 дахин өсч, Сүхбаатар сумын 4, 5-р багт Цагааннуур, Түшиг, Мандал, Сайхан, Сант сумдад 16.7-63.5 хувиар, Сүхбаатар сумын 2, 8-р баг, Жавхлант, Зүүнбүрэн, Баруунбүрэн сумдад 1-4 дахин тус тус буурч, Шаамар, Дулаанхаан тосгон, Ерөө, Хушаат, Орхонтуул сумдад өнгөрсөн оны мөн үетэй адил түвшинд, суманд шиг, Сайхан, Сант 33.3-66.7 сумдад хувиар, Сүхбаатар сумын 2, 8 дугаар баг, Жавхлант, Зүүнбүрэн, Хушаат сумдад 1-4 дахин хувиар тус тус буурч, Сүхбаатар сумын 7 дугаар баг, Дулаанхаан томгон, Мандал сумдад өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна гэсэн тоон үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд 2017 оны 3 дугаар сард 161 төрөлт, 32 гэрлэлт бүртгэгдэж, 685 иргэнд цахим үнэмлэх, 45 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт, ОХУ-ын хавсралт 3657 ширхэг олгож, аймаг, хотруу шилжин явсан 132, шилжин ирсэн 187, сум дүүрэгт шилжин ирсэн 88, сум дүүрэгт шилжин явсан 77, баг хооронд шилжин ирсэн 129, баг хооронд шилжин явсан 131 шилжилт хөдөлгөөн бүртгэгдээд байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлд 530 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 530 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамж 52.525 төгрөг, үйлчилгээний хураамж 2.028.961 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татвар 5.312.000 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

## **2.Архивын талаар**

Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэлийн программд оруулах төрийн архивын хөмрөг үүсгэгч байгууллагуудын нэрсийн жагсаалт болон мэдээ оруулах, баталгаажуулах ажилтнуудын судалгаа мэдээллийг гаргаж Архивын Ерөнхий газарт хүргүүлж, ойн техник мэргэжлийн сургуулийн хөмрөгийн дансыг ажлын хэрэгцээнд түр шилжүүлэн авч тооллогын ажилд ашиглан тоо бүртгэлийн үндсэн болон туслах баримт бичгүүдийн бүрэн эсэхийг шалгаж хөмрөгийн баримтуудыг данстай нь нэг бүрчлэн тулгаж тоолон дутагдаж алга болсон баримтуудыг олж тэдгээрийн шалтгааныг тогтоох ажлыг хийсэн. Мөн хөмрөгийн 1972-2001 оны 47 хн-д иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийсэн. Дансны бүрдлийг хангахын тулд дансны шилжүүлэх хүснэгт, нэр төрлийн заагуур, баримтын түүх, хөмрөгөөс хассан баримтын акт, устгах бичгийн жагсаалтыг гаргаж ББНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Мөн дансны шинэчилсэн бүртгэлийг гаргаж Төрийн архивын АМС программд шивж, Зүүнхараагийн Хүнсний үйлдвэрийн хөмрөгийн 1954-1991 оны 153 хн-д хэсэгчилсэн тооллого хийж, Хонд амралт, Ойн ТМС-ийн хөмрөгийн 42 хн-ний 4920 хуудас баримтуудыг скайнердаж мастер хувь үүсгэсэн.

Ард иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу цахим хэлбэрээр архивын хуулбар 192, мастер хувиар 51, цаасан суурьтай баримтнаас 35 лавлагаа гарган нийт архивын лавлагаа 278, цалингийн тодорхойлолт 12 гаргаж үйлчилсэн байна.

## **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

### **1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:**

Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, цаг үеийн шаардлагатай асуудлуудаар мэдээлэл хүргэх зорилгоор сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн сургалт семинарыг зохион байгуулж суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын явц, үр дүн, цаашид анхаарах асуудлыг судлагдахуун бүрээр танилцуулж, хэлэлцүүлээ. Боловсролын салбарын мэдээллийн системд мэдээллийг оруулах, боловсруулах, багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журмыг хэрэгжүүлэх, элсэлтийн ерөнхий шалгалт болон ном, сурах бичгийн хангалт, “Хүүхдэд ээлтэй сургууль”, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” болох, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх,

насан туршийн боловсролын чиглэл болон дүрэмт хувцасны хангалтын талаар мэдээлэл хийлээ.

Мөн боловсролын салбарын төсөв, төсвийн гүйцэтгэл, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, мэдээллийг байршуулах, сургуулийн гамшгаас хамгаалах менежмент, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах арга зүй, Ахмад багш нарын холбооны мэдээллийг хийсэн.

Стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн худалдан авах чадвар эзэмшүүлэх, худалдан авч буй бараа бүтээгдэхүүний талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, үйлчилгээний соёл, дадал эзэмшүүлэх зорилгоор Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу бага, дунд, ахлах ангийн сурагчдад 10-15 минутын мэдээлэл өгөх талаар чиглэл өгч сургуулиудад хүргүүлсэн.

2016-2017 оны хичээлийн жилийн төрөлжсөн олимпиадын 2, 3-ын давааг БСШУСЯ-аас ирүүлсэн хуваарийн дагуу зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудын ажил үйлчилгээнд шаардлагатай хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, эрсдэл бүхий хүүхэдтэй ажиллах ур чадвар, арга зүйг сайжруулах, тэдний ажилд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүүхдийг гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэхэд сургуулийн нийгмийн ажилтны үүрэг оролцоо ” сэдэвт сургалтыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэмжлэгтэйгээр зохион байгууллаа.

Соёлын төвийн хөгжмийн багш нарт зориулсан “Mixcraft” программыг ашиглан дууны бичлэг боловсруулах арга зүй сургалтыг 2017 оны 3 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Улаанбаатар хотын “Art” студитэй хамтран зохион байгуулж 17 сумын Соёлын төвийн хөгжмийн багш 1 сургуулийн хөгжмийн багшийг хамруулж “Mixcraft” программыг ашиглан хөгжмийн зэмсэг хэрэглэхгүйгээр 2 дууны фонограммыг боловсруулж амжилттай суралцлаа.

Сэлэнгэ аймагт биеийн тамир, спортын сарбар үүсч хөгжсөний 70 жилийн ойн нэрэмжит аймгийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнийг 3 насны ангилалаар зохион байгууллаа.

## **2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:**

2017 оны 02-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 849 байсан бол 122 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 67 ажлын байранд 54 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 28 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 889 болсон байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн яам (хуучин нэрээр), БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хооронд байгуулсан Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу “БНСУ-д ажилчид илгээх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд Солонгос хэлний түвшин тогтоох 13 дахь удаагийн шалгалтын бүртгэлийг 3 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд зохион байгуулж, 55 эмэгтэй, 195 эрэгтэй, нийт 250 иргэний бүртгэлийг хийж, холбогдох материалыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн.

Нийгмийн халамжийн сангаас 03 сарын байдлаар 24035 иргэнд 2,893,827,342 төгрөгийг олгоод байна.

## **3.Эрүүл мэндийн талаар**

“Сүрьеэгүй Сэлэнгийн төлөө хамтдаа” сургалт зөвлөгөөнийг Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн холбогдох мэргэжилтнүүд, сум тосгодын Засаг дарга, эрүүл мэндийн төвүүдийн дарга нар, лаборант 80 гаруй хүнийг хамруулан зохион байгуулсан. Мөн “Эрүүл Сэлэнгэ” болзолт уралдааныг 3 сарын хугацаатай зарлан бүх өрх, сум, тосгодын эрүүл мэндийн төвийн дарга нарт танилцуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

Сүхбаатар сумын 6-р сургуультай хамтран энэ сарын 15-нд “Өсвөр үеийн эрүүл мэнд” сэдвээр эцэг эхчүүдэд сургалт хийж, нийт 180 гаруй хүнийг хамруулснаас гадна “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих” жилийн ажлын хүрээнд Шийдвэр гүйцэтгэх алба, Хорих 413 дугаар ангийн албан хаагч, настан 131 хүнд нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгийг үнэ төлбөргүй хийсэн.



#### **4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:**

Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалт, сурагчдын дунд мэтгэлцэх, илтгэх урлаг хөгжиж байгаатай холбогдуулан чөлөөт цагийг үр ашигтайгаар өнгөрүүлэх, хоорондын харилцаа холбоог сайжруулах, оюуны хөрөнгө оруулалт хийх, чадваржуулах сургалтыг зохион байгуулж 40 гаруй хүүхэд хамрууллаа.

Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч 10 төвд 156 хүүхдийг хамрагдаж байгаа бөгөөд "Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох" журмын дагуу хүүхэд харах үйлчилгээ болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн давхардлыг аймгийн Боловсрол, соёл урлагийн газартай хамтран шалгалаа.

#### **5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар**

Нийгмийн даатгалын сангуудад 6401,3 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулахаас 6091,8 сая төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 95,2 хувьтай байна.

Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн, амаржсан, оршуулгын зардалд 2017 оны 1-р улиралд 1551 иргэнд 507,5 сая төгрөг, тэтгэврийн даатгалын сангаас 15428 тэтгэвэр авагчдад 1,3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, ажилгүйдлийн даатгалын сангаас 151 даатгуулагчид 206,2 сая төгрөгийг, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 229 даатгуулагчид 273,1 сая төгрөгийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн ослын тэтгэмж, сувилалын зардал олгож, эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг эмийн сангуудаар үйлчлүүлсэн 29469 даатгуулагчдад 939,5 сая төгрөгийн эмчилгээний болон эмийн үнийн хөнгөлөлт үзүүлсэн.

2017 оны 1-р улирлын байдлаар шинээр өндөр насны 157, тахир дутуугийн 87, тэжээгчээ алдсаны 16 нийт 260 тэтгэвэрийг тогтоон нийт 15375 тэтгэвэр авагчдад 13457,4 сая төгрөгийн тэтгэвэрийг арилжааны банкуудаар дамжуулан олголоо.

#### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

МАА-н үйлдвэрлэлд нийт сумдын нутгаар мал нэмэгдэл тэжээлд орсон. Ихэнх сумдын нутгаар мал төллөлт эхэлсэн бөгөөд Хушаат, Зүүнбүрэн, Ерөө, Цагаануур Хүдэр, Жавхлант, Алтанбулаг сумдын нутгаар цас ихтэй байгаагаас малын бэлчээрлэлт саатсан. Нийт нутгаар цас ихтэй байгаагаас хаваржилт хүндрэх төлөвтэй байна.

2017 онд нийт 733364 эх мал төллөхөөс 03 дугаар сарын 24-ний байдлаар нийт 86424 мал төллөж үүнээс ингэ 4, гүү 171, үнээ 4974, хонь 50649, ямаа 30626 төллөөд байна.Төлийн хорогдлын хувьд 2411 үүнээс унага 1, тугал 106, хурга 1111, ишиг 1193 хорогдсон дүн мэдээтэй байна. Мал төллөлт жигдэрч эхлээд байна. 03 дугаар сарын 24-ний байдлаар малын зүй бус хорогдлын хувьд нийт 20756 байгаа бөгөөд үүнээс адуу 383, үхэр 2364, хонь 11016, ямаа 6993 үүнээс хээлтэгч 5865, өвчнөөр 3638 бусад нь зүй бусаар хорогдсон мэдээтэй байна.

Сумдын хөдөө аж ахуйн тасгуудын 2016 онд аймгийн ХХААГ-ын даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэж, 2017 онд хамтран ажиллах ХХААГ, сумын Засаг дарга, ХААТ тус тус мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний стандартыг хангуулах зорилгоор гурвалсан гэрээг байгуулах, ажил төрлийн семинарыг зохион байгууллаа. Мөн халдварт өвчний сэжиг бүхий хөдөө орон нутгаас ирсэн дуудлаганд шуурхай хариу өгч мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.

Алтанбулаг, Зүүнбүрэн, Түшиг, Шаамар зэрэг сумдаас ирсэн өвчилсөн, хорогдсон мал, амьтны эмгэгт 38 дээжинд стандарт арга зүйн дагуу оношлогоо шинжилгээг хийж Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораториор баталгаажуулан хариуг өгсөн бөгөөд халдварт өвчний үүсгэгч илрээгүй байна. Мөн

Зүүнбүрэн сумаас тугал-3, Алтанбулаг сумаас хонь-1, нийт 4 бүтэн хүүрэнд задлан шинжилгээ хийж үзэхэд тэжээл боловсруулах эрхтэнд хоол тэжээл ус байхгүй, уураг сүү нь бөөмтсөн байсан.

Хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд 4,2 тн мах, махан бүтээгдэхүүний 72 дээж, 0.8 тн сүү, сүүн бүтээгдэхүүний 32 дээж, 364 өндөгний 9 дээж, 215 ш арьс ширний 22 дээж, 0.9 тн ноос, ноолуурын 27 дээжинд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийж баталгаажуулан гэрчилгээ олгосон.

ЖАЙКА, JAICAF-н "Зөгийн аж ахуйг дэмжих, үр ашгийг нэмэгдүүлэх" төслийн багийхантай хамтран зөгийчдийн сургалт зохион байгуулж, зөгийний өвчин, тухайн өвчинд эмийн бодисыг хэрхэн зөв зохистой хэрэглэх, тэдэнд зөгийн өвчний бүртгэл хэрхэн хийх, зөгийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, зөгийний өвчин гарсан үед малын эмчийн үүрэг оролцоо, шаардлага хангасан эмийн зохистой хэрэглээг бий болгох, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь зөгийн аж ахуйн эрсдлийг багасгаж, үр ашгийг нэмэгдүүлэх ач холбогдолтой болох талаар мэдээллийг хийсэн. Мөн Шаамар суманд зохиогдсон "Зөгийн аж ахуйг дэмжих, үр ашгийг нэмэгдүүлэх зөвлөгөөнд зөгийн аж ахуй эрхлэгч иргэд, нөхөрлөлийг оролцууллаа.

Хөрсний өнгөн үе Сүхбаатар, Зүүнбүрэн, Түшиг, Хушаат сумдын нутгаар 03 дугаар сарын сүүлээр, бусад сумдын нутгаар 4 дүгээр сарын эхээр гэсэх төлөвтэй байна. Уринштай талбайд хаврын угтвар ашигтай чийгийн нөөцийн урьдчилсан төлөвөөр уриншийн талбайд Алтанбулаг, Мандал, Орхон, Сайхан сумдын нутгаар 0-20 см-ийн гүнд буюу дунд зэрэг, бусад сумдын нутгаар хангалттай, бусад сумдын нутгаар чийг хангалттай

Гуурстай талбайд 0-20см-ийн гүнд Баянгол, Мандал, Сант, Баруунбүрэн, Орхон сумдын нутгаар хангалтгүй, Хушаат, Сайхан сумын нутгаар дунд, бусад сумдын нутгаар хангалттай, 0-50 см-ийн гүнд Баянгол, Мандал, Сант сумдын нутгаар хангалтгүй, Орхон, Хушаат, Сайхан сумдын нутгаар дунд зэрэг, 0-100см-ийн гүнд Баянгол, Сант сумдын нутгаар хангалтгүй, Мандал, Орхон, Хушаат, Алтанбулаг, Сайхан сумдын нутгаар дунд зэрэг, бусад сумдын нутгаар хангалттай гэсэн үнэлгээтэй байна.

### **Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:**

#### **1.Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын талаар:**

Цахим худалдан авах ажиллагааны систем /[www.tender.gov.mn/](http://www.tender.gov.mn/) сайтад 17 сумын 2017 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулж, сумдын төлөвлөгөөг тухай бүр нь хянан шалгаж баталгаажуулан ажиллаж байна.

Аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн саравчийг гүйцээх, стандарт таримал зүлэгтэй хөл бөмбөгийн талбай байгуулах ажлын нээлт хийж үнэлгээний шатандаа байна. Ерөө сумын ашиглалтын бүсийн ойн санд ой зохион байгуулалтын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх зөвлөх үйлчилгээний дэлгэрэнгүй жагсаалтанд 3 компани бүртгэн тендер шалгаруулалтаа үргэлжлүүлэн ажиллаж байна.Улсын төсвөөс эрх шилжиж ирсэн 2 ажил, орон нутгийн хөгжлийн сангийн 1 ажлын ажлын хэсгийг байгуулан тендерийн баримт бичгийг бэлтгэн ажиллаж байна.

Selenge.gazargov.mn албаны цахим хуудсанд 2017 онд иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг баталсан тогтоолыг сум тус бүрээр гарган, Сүхбаатараас Алтанбулаг чиглэлийн улсын чанартай авто замын дагуух газарт иргэдэд өмчүүлэх газрын байршлыг зургийн хамтаар байршуулсан.

Улсын бүртгэлийн хэлтсээс сумдын улсын бүртгэгч нарын нэгдсэн сургалтыг зохион байгуулж тус сургалтанд аймгийн хэмжээнд “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх ажлын өнөөгийн байдал” сэдвээр мэдээлэл хийж, өмчилсөн газрыг улсын бүртгэлд бүртгүүлэх, гэрчилгээ олгоход гарч буй хүндрэл бэрхшээл, эзэмших эрхийн гэрчилгээний барьцааны талаар харилцан санал солилцож нэгдсэн ойлголтод хүрлээ.

Сэлэнгэ аймгийн сумдууд болон төв суурин газрын газар доорхи шугамын судалгааг гарган 2017-03-10 өдрийн 1/122 тоотой Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлэв.

Газрын харилцааны албан хэрэгцээнд ашиглагддаг аймагсад мэдээллийн сангийн баазад энэ сард нийт 16 сумын газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын 185 нэгж талбар хувийн хэргийн мэдээллийг шивж орууллаа.

## **2. Байгаль орчны талаар:**

2017 оны 03 дугаар сарын 03, 06, 10-нд бүх сумдын нутгаар, 05-нд нутгийн хойд хэсгээр, 06-нд нутгийн өмнөд хэсгээр 0,0-4,0мм цас орсон. Бусад хугацаанд цас ороогүй. Ихэнх хугацаанд салхи баруун хойноос болон баруунаас 4-9 м/сек. Ихэнх сумдын нутгаар цасан бүрхүүлтэй, Ерөө, Цагааннуур, Зүүнбүрэн, Хушаат Бугант, Түшиг, Хүдэр сумдын нутгаар цасны зузаан 6-33см, цасны нягт 0,11-0,26г/см<sup>3</sup>, бусад сумдын нутгаар цасны зузаан 1-16см, цасны нягт 0,11- 0.22г/см<sup>3</sup> байна. Хушаат, Зүүнбүрэн, Ерөө, Цагааннуур Хүдэр, Жавхлант, Алтанбулаг сумдын нутгаар цас ихтэй байгаа тул хунгар газартаа 24-36см зузаан цастай байна. 1-р арав хоногт шөнөдөө 25-30 градус, өдөртөө 13-18 градус, 2-р арав хоногийн сүүлээр хүйтэрч шөнөдөө 35-43 градус, өдөртөө 22-27 градус, бусад хугацаанд шөнөдөө 33-38 градус, өдөртөө 20-25 градус хүйтэн байлаа. II-р арав хоногийн байдлаар 03 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар голуудын мөсний зузаан Сэлэнгэ-Зүүнбүрэн 80см, Сэлэнгэ-Сүхбаатар 0см, Орхон-Сүхбаатар 65см, Орхон-Орхон 85см, Ерөө-Ерөө 50 см, Хараа-Баруунхараа 100 см, Зэлтэр-Зэлтэр 50 см, Хүдэр-Хүдэр 65см, Ерөө-Дулаанхан 55см байна. Сэлэнгэ аймгийн хэмжээнд голуудын мөсний зузаан олон жилийн дундажаас 10-71 см-ээр бага байна.

Сүхбаатар суманд агаарын бохирдол, гадаргын усны гидрохимийн шинжилгээ, цацрагийн түвшин нь стандарт хэмжээнээс хэтрээгүй байна. Агаар дахь түгээмэл бохирдуулагч хий болох азотын давхар ислийн дундаж агууламж 0.014 мг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж 0,028 мг/м<sup>3</sup>, хүхэрлэг хийн дундаж агууламж 0,005 мг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж 0,009 мг/м<sup>3</sup> байв.

Сэлэнгэ-12 дугаар зөрлөг, Орхон- Шаамар, Орхон-СБ ус судлалын харуул дээрээс усны дээж авч гидрохимийн шинжилгээг хийж үр дүнг гаргасан. Сүхбаатар сумын “Урсгал-Ус” ХХК-ний цэвэрлэх байгууламжийн хаягдал уснаас дээж авч шинжилгээ хийхэд тус цэвэрлэх байгууламжийн усны цэвэршилт 36.9 хувийн цэвэршилттэй байна.

## **Долоо.Сум орон нутгийн талаар:**

### **Алтанбулаг сум:**

Энэ сарын 13-нд “Эрчүүд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд” сэдэвт өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгийн үйл ажиллагаанд Эрчүүдийн эрүүл мэндийн талаар товч мэдээлэл хийж, 68 иргэнд “Эрчүүдийн эрүүл мэндийн аюулын 10 дохио” гарын авлага тарааж эрүүл мэндийн боловсрол олгосон. Мөн байгууллага, аж ахуй нэгжийн албан хаагчдад “Бэлгийн замын халдварт өвчин”, “Сүрьеэ эдгэрдэг өвчин” сэдвээр сургалт хийж, сургууль, цэцэрлэг, банк зэрэг албан байгууллагын 100 гаруй ажилтан хамрагдаж, гарын авлага тарааж эрүүл мэндийн 4 төрлийн үзлэгийг хийсэн.

Бага насны хүүхдийг аливаа осол гэмтлээс сэргийлэх үйл ажиллагааны нэг хэсэг нь түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх, түлэгдсэн үед анхан шатны тусламж үзүүлэх талаарх сургалтыг “Найрамдал”, “Дамбо” цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний төвд зохион байгуулж, эцэг эхийн төлөөллийг оролцуулж, хийн түлш, гал түймрийн талаарх сэрэмжлүүлэг, ахуйн осол, галын аюулаас урьдчилан сэргийлэх тухай гарын авлага тарааж, мэдээлэл өглөө.

Улсын нөөцөөс хуваарилагдсан 2000 боодол өвс, 50%-ийн хөнгөлөлттэй /4650 төгрөг/ өртөгтэй 800 шуудай хивгийг 189 өрхөд олгосон. Дуудлагын дагуу 5 малчин өрхөд очиж малд үзлэг хийж, зөвөлгөө өгсөн ба сумын МЭҮН-үүдтэй хариуцлагын гэрээ байгуулан ажиллалаа.

### **Зүүнбүрэн сум:**

Сумын Засаг даргын “Гамшгийн аюулын дохиогоор ажиллах, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” 2017 оны А/36 тоот захирамжийн хүрээнд газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн анги, албад хэрхэн ажиллах талаарх сургалтыг зохион байгуулж, газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг харуулсан видео бичлэг үзүүлж, 7 техник мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд 76 иргэнийг хамруулсан дадлага сургуулилтыг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх “Хүнээ дээдлэн, үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, хөгжилд түүчээлнэ” хөтөлбөрийг төр, төсвийн байгууллага иргэдэд сурталчлах арга хэмжээг зохион байгуулснаас гадна Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуультай хамтран “Хууль сурталчлах” арга хэмжээг зохион байгуулж, Нийгмийн даатгал, Нийгмийн халамж, Газрын тухай хууль, Хог хаягдлыг устгах тээвэрлэх журам, “Амьдралын зөв хэв маяг” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж 32 иргэнийг хамрууллаа.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан оны шилдэг 10 эмэгтэй шалгаруулах ёслолын ажиллагааг зохион байгуулж, Орчин цагийн зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 96 жилийн ойн баярыг тохиолдуулан ахмад “Хадланчдын алдар”- тэмдэглэх ёслолын арга хэмжээ, баярын концерт, Сагсан бөмбөгийн тэмцээнийг тус тус зохион байгууллаа.

Дэлхийн усны өдөр болон цаг уурчдын баярын өдрийг тохиолдуулан “Усны зөв зохистой хэрэглээ”, “Цаг уурчдын ажлын онцлог”-ын талаар мэдээлэл хийн, хөгжөөнт тэмцээн зохион байгууллаа.

Бага насны хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлж, хүүхдийн осол, эндэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхдийн түлэгдэл - Эцэг эхийн хариуцлага” сургалтыг зохион байгуулж 132 эцэг эхчүүд, 21 багш, ажилчдыг тус тус хамрагдлаа.

Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн сурагчдын дунд “Хүүхдээ сонсьё” арга хэмжээг зохион айгуулан 250 хүүхэд хамрагдан “Тулгамдсан асуудал-миний оролцоо” сэдвээр санал асуулганд хамрагдан гарсан саналаа багш нартаа хүргүүллээ.

Газар тариалангийн салбарт хэрэгжиж буй төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, салбарын үйл ажиллагааны талаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлох зорилготойгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулж буй хэрэглэгчдийн үнэлгээ судалгаанд 16 иргэн хамрагдлаа.

Хувийн МЭҮН-д эмийн нөөц багсаж цаашид шаардагдах эмийн захиалгыг гаргалаа. МЭҮН-д 2 аж ахуй нэгж, 24 иргэнд малын төрөлтийн хүндрэлийн 35 дуудлагаар үйлчилгээ үзүүллээ.

### **Мандал сум:**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу багийн Иргэдийн нийтийн хурлаас багийн Засаг даргад нэр дэвшиж, улмаар олонхийн саналаар багийн Засаг даргаар томилогдсон албан хаагчдыг батламжлах ёслолыг 2017 оны 03 сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Төмөр замчдын 1-р багийн Засаг даргаар Б.Сүхболд, Ширхэнцэгийн 2-р багийн Засаг даргаар Д.Гэрэлцэцэг, Баянсуудалын 3-р багийн Засаг даргаар Ц.Сармандах, Хэрх 4-р багийн Засаг даргаар А.Дашзэвэг, Түнхэл 5-р багийн Засаг даргаар Ч.Оюунгэрэл, Баянхангайн 6-р багийн Засаг даргаар Б.Ганчулуун, Минжийн хангайн 7-р багийн Засаг даргаар С.Удаанжаргал, Тарни 8-р багийн Засаг даргаар Н.Батбаяр, Баян-Арцатын 9-р багийн Засаг даргаар Б.Дорждэрэм нар тус тус томилогдож батламж, тамгаа гардан авлаа.

Багийн Засаг дарга, Багийн иргэдийн нийтийн хурлын дарга, Багийн нийгмийн ажилтан, Тосгоны төрийн захиргааны албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор нийт 31 албан хаагчдад Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Төрийн захиргааны

байгууллагын уялдаа холбоо, Сумын эдийн засаг нийгмийн суурь үзүүлэлтүүд, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, Цагийн менежмент, Баянсуудлын 3-р багийн туршлага зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгууллаа.

Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 96 жилийн ой, Монгол цэргийн баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүлж баярын хурал зохион байгуулан, цэрэгжүүлсэн байгууллагуудын дунд марш тактикийн тэмцээн зохион байгуулж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хорих 413-р анги тэргүүн байр эзэллээ.

Гамшийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургалт зохион байгуулах ажлыг Хэрх Захирагчийн албан, Хэрх ЭМТ, Хэрх Соёлын төвийн албан хаагчид хамтран зохион байгууллаа Багийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг цуглуулан нүүлгэн шилжүүлэлтийн үед зохион байгуулагдах арга замын талаар Онцгой байдлын газрын гал унтраах 19-р ангийн Ахлах дэслэгч М.Итгэлпүрэвээс заавар зөвлөгөө авч 2017 оны оны 03 дугаар сарын 22-ны өдөр 3 төсвийн байгууллага, Хаан банк, Төрийн банкны албан хаагчид нийт 30 албан хаагчийг хамруулан сургалтыг зохион байгуулсан. Багийн гамшгийн аюулын дуут дохиогоор ажиллах төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг Хэв журам сахиулах бүлэг, Бүртгэл мэдээлэл хариуцсан бүлэг, Холбоо мэдээлэл хариуцсан бүлэг, Инженерийн бүлэг техникийн бэлэн байдлыг хангах бүлэг, Хоол хүнсний хангалтын бүлэг, Аврах бүлэг, Эмнэлэг, эрүүл ахуй, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлэг болгон 8 хусэгт хуваан 38 хүнийг хамруулан дадлага сургуулилт явууллаа.

Казак түмний хаврын баяр буюу Наурызын баярын өдөр сумын удирдлагууд Түнхэл тосгоны казак үндэстэн иргэдэд хүндэтгэл үзүүлж ахмадуудад золгон, баярын хуралд оролцлоо.Хурлын үеэр сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулсан иргэдэд төрийн дээд одон медаль болон сумын Засаг даргын хүндэт өргөмжлөл гардууллаа.

БНСУ-ын Чэжү хоттой тогтоосон найрамдалт харилцааг бэхжүүлж тус хотын төлөөлөгчдийг сумын Засаг дарга Н.Лхагвадорж хүлээн авч уулзлаа. Уулзалтаар хоёр хотын цаашдын хамтын үйл ажиллагааны талаар хэлэлцэж, үйлдвэрлэл үйлчилгээ, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцуулахын зэрэгцээ дэд бүтэц, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төсөл хөтөлбөрүүдийг өргөн барилаа.

“Дэлхийн номын өдөр”-ыг угтан Нийтийн номын сан, Соёлын төв, ЕБС-ийн номын санч нарын идэвх санаачлагыг өрнүүлэх, уулзалт, сургалт, тэмцээн зохиож харилцан туршлага судлаж, тэдний харилцаа холбоог бэхжүүлж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор “Мэргэжил арга зүйн” сургалт өдөрлөг зохион байгуулж, “Номын сангийн анхан шатны бүртгэл хөтлөлт”, “Номзүйн бичилт, номын сангийн ангилал”, “Monbiblio программын тухай” , “СОНА зохион байгуулалт”, Мишээл цэцэрлэгийн багш “Номын сурталчилгааг театрчилсан дүрийн тоглолт хэлбэрээр бэлтгэх” сургалтуудыг явуулж, нийт 10 номын сангын 13 номын санч хамрагдлаа.

Нийтийн номын сангийн шинэ уншигчаар 1369 хүн бүртгэснээс гэрээр ном олгох карт 9 хүнд олгож, 3146 ирэгсэдэд 5108 ном хэвлэл олгож уншууллаа. Monbiblio программын цахим бүртгэлд шинээр карт нээлгэсэн1369 уншигчийг 100% программд бүртгэлээ. Номын сурталчилгааны ажлаар Дамбын Төрбатын “Төрийн соёрхол” түүхэн цуврал роман 12ш, “Дэлхийн усны өдөр”-т зориулж 24ш, шинэ ирсэн 12ш нийт 48ш номоор уншлагын танхимуудад үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

Нийгмийн зорилтот бүлгийн иргэдийг нийгэмшүүлэх зорилгоор “Аз жаргал дүүрэн гэр бүл” өдөрлөг зохион байгуулж, өдөрлөгт 20 гэр бүл амжилттай оролцож эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбатын санаачлагаар 2017 оны 3 дүгээр сарын 10-нд сумын удирдлагууд, нэгдсэн эмнэлэгийн 23 эмч нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид АШУҮИС-д зочлон тус сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллахаар шийдвэрлэлээ.

Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдөрт зориулсан "Сүрьеэгүй ирээдүйн төлөө нэгдэцгээе" сэдэвт "Мандал марафон-2017" гүйлтийн тэмцээнийг зохион байгуулж, 4 насны ангилалд нийтдээ 205 хүн гүйлээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн 102, Алдарт эхийн одонгийн 1250 иргэний материал нийт 1352 материал хүлээн авч Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдугаар уулзалтыг зохион байгуулж дарга тэргүүлэгчдийн сонгон 2017 оны төлөвлөгөө гаргаж ажиллалаа.

### **Орхон сум:**

Тайлант сард төр, төсвийн байгууллагаас зохион байгуулж арга хэмжээний мэдээллийг хүргэсэн "Тайлан мэдээлэл-санал шийдэл" уулзалт арга хэмжээг энэ сарын 23-ны өдөр зохион байгуулж, сумын ИТХ-ын тогтоол шийдвэр, сумын Засаг даргын захирамжуудыг танилцуулж, е-баримт бүрдүүлэх талаар болон улсын бүртгэлийн тухай хууль, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 2017 онд үзүүлэх үйлчилгээ, төсөл хөтөлбөрүүдийн талаар танилцуулга хийлээ.

Тус суманд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Хос булаг" ХХК, "Мөнх-Орхон" ХХК, "Пубосс" ХХК, "Орхондалай", "Баюудай трейд" ХХК-ны, "Мангирт трейд" ХХК, "Өнгөт" ХХК-ны захирлууд хамтран эмнэлгийн зориулалтай 8 ш орыг сумын Эрүүл мэндийн төвд хүлээлгэн өглөө.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн баяр, Зэвсэгтхүчний 96-н жилийн ойн арга хэмжээг зохион байгуулж, Худалдаа үйлдвэрлэлийн тэргүүний ажилтан Ж.Лхамжавын нэрэмжит сумын аварга шалгаруулах сагсан бөмбөг тэмцээн, "Тэнгэрлэг эрчүүд" баярын концерт боллоо.

Тайлант сард "Хүүхдийн түлэгдэл-эцэг эхийн хариуцлага" аяныг сумын эрүүл мэндийн төв, сургууль цэцэрлэгүүд хамтран зохион байгуулж, *Orkhon sum zdtg, Selenge Orhon EMT* цахим хаягаар ахуйн осол гэмтэл, түлэгдэлтээс үр хүүхдээ хэрхэн хамгаалах вэ, түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламж зэрэг мэдээллийг нийт эцэг эхчүүдэд анхааруулга сэрэмжлүүлгийг нийтэлж, гарын авлагыг 28 айл өрхийн 112 иргэнд тараан сурталчилгаа хийсэн.

Сурагчдын стандарт мэдлэгийг хангах зорилгоор ээлжит хичээлийг чанартай хөтлөн явуулахын зэрэгцээ сургуулийн хэмжээнд Мини- олимпиадыг монгол хэл, математикийн хичээлээр зохион байгуулахад 179 сурагч хамрагдан мэдлэг, чадвараа үнэлүүлж, гүйцээх болон нэмэлт давтлагад нийт 222 сурагч хамрагдсан байна. Мөн Хүүхэд бүрийг хичээлээр болон хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар I-XII ангийн сурагчдын дунд хүүхэд хөгжүүлэх "Зочинтой хичээл", "АХА", "ТА та тунга", "Өв соёлоо тээн түгээн дэлгэрүүлэх" илтгэлийн уралдаан, "Бид ирээдүйн манлайлагчид" хөтөлбөрт ажлын хүрээнд физик, биологи, технологийн багш нар мэргэжил сурталчлах ажил, "Дээлтэй Монгол өдөрлөг", "Өвлөн наадъя", "Бид уран уншлагатан", "Өвлөн дуулья", "Гэгээн хайрын өдөр", "Сэтгэлийн бэлэг", "Цагаан сарын баярын зан үйлээс суралцах нь", "Ээждээ барих миний бэлэг", "АХА", Бид сурагч" зэрэгнийг 13 хөтөлбөрт ажлыг 620 сурагч хамруулж зохион байгууллаа. Мөн уламжлал болгон зохион явагддаг "Кенгуру" олон улсын олимпиадад II-XII ангийн 14 сурагч оролцож өөрсдийн оюун ухаан сэтгэх чадвараа сорилоо. "Өв соёлоо тээн түгээн дэлгэрүүлэх" үндэсний бичгийн олимпиад 6,7-р ангийн 43 сурагчийг бэлтгэж, үндэсний бичгээр унших чадварыг сорилоо.

Орхон бүсийн аврага шалгаруулах уран илтгэлийн тэмцээнд "Уран илтгэл" дугуйлангийн 15 сурагч оролцож 11 а ангийн сурагч Г. Номин Гурав дугаар байр, мөн Сургуулийн аврага шалгаруулах уран илтгэлийн тэмцээнд 6-11 ангийн 19 сурагч оролцсоноос 7а ангийн сурагч А. Амин-Эрдэнэ тэргүүн байр, 7а ангийн сурагч Э. Энхжин дэд байр, 11а ангийн сурагч Г. Аригуун, 9а ангийн сурагч Б. Ану нар гутгаар байр эзэлсэн. Мөн "Орхоны яргуй-2017" дунгийн эгшиг наадамд дунд, ахлах ангийн 16 сурагч оролцож ахлах, дундангийн төрөлд сурагч Э.Оюунтөгс /8а/, "Нацагдорж" тэмдгээр Б.Ану /9а/ "Тэргүүн", П.Номин /8а/, Г.Аригуун "Дэд", А.Мөнхжин /11а/ "Гутгаар" байрыг тус тус эзэлж бусдыгаа манлайлсан.

### **Сант сум:**

Тайлант сард Засаг даргын зөвлөл 2 удаа хуралдаж хүн амын унд, ахуйн зориулалтаар хэрэглэх усны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоож мөрдүүлэх, ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн сургалт болон санхүүгийн ажлыг сайжруулах талаар хэлэлцэж сургуулийн удирдлагад хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан байна. Усны тухай хууль шинэчлэн найруулагдсантай холбоотойгоор хүн амын унд, ахуйн зориулалтаар хэрэглэх усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2013 оны 326 тогтоолоор тооцоолон шинэчлэн тогтоож энэ сарын 17-ны өдрөөс эхлэн мөрдөж эхэллээ. Эрүүл цэвэр орчинг бүрдүүлэх зорилгоор сумын төсвийн байгууллага, аж ахуйн нэгжүүд байгууллагын гадна орчны болон нийтийн эзэмшлийн зам талбайн хогийг цэвэрлэж 12 м/куб хогийг нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн хаясан байна.

Аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжийн дагуу гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж аюулгүй газар шилжин байрших дадлага сургуулийг сумын хэмжээнд 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 16:00 цагаас зохион байгуулж нийт 9 аж ахуйн нэгж байгууллага, 132 иргэн хамрагдсан байна. Энэ ажлын хүрээнд сумын ААНБ-ын удирдлагуудад үүрэг чиглэл өгч сумын ЗДТГ-ын цахим мэдээллийн самбараар зарлан мэдээллийн дохио дамжуулах дадлага сургуулийн талаар олон нийтэд сурталчилж шинэчлэн найруулагдсан “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн талаар мэдээлэл өгч ажилласан байна.

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын ИТХ, ЗДТГ, ГХУСАЗСЗөвлөл, Бүрэн дунд сургууль хамтран 9-12-р ангийн сурагчдын дунд “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хүүхэд бидний оролцоо” сэдэвт шилдэг илтгэлийн уралдааныг тодорхой удирдамжийн дагуу зохион байгуулсан юм. Мөн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, айх аюулгүй, амгалан тайван аж өрөх нөхцлийг бүрдүүлэхэд иргэн бүрийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож архины хэрэглээг багасгах, архидалтыг хэрхэн арилгах талаар санал солилцож сум, баг, аж ахуйн нэгж, гэр бүлээрээ “Архийг зөв боловсон хэрэглэж, аливаа баяр ёслолыг архигүй тэмдэглэн өнгөрүүлэх уриалгыг гаргасан. Сумын нутгийн зөвлөл, сумын ЗДТГ-ын хамтран ажиллах санамж бичигт тусгасан төлөвлөгөөний дагуу “Эрүүл аюулгүй зөв амьдрал, сургалт өдөрлөг”-ийг зохион байгуулж харилцааны доктор Н.Алтанцоож “Амжилтын гарц, зөв харилцаа” лекц, сэтгэц наркологийн төвийн эмч н.Мөнхтуяа “Архины хор уршиг” сэдвээр сургалт мэдээллийг хүргэсэн байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Эмэгтэйчүүд бидний оролцоо” чуулга уулзалтыг сумын “Эрүүл мэндийн төв”-өөс санаачлан зохион байгуулж 258 эмэгтэй хамрагдсан байна. Чуулганы үеэр хөдөлмөр бүтээлээрээ шалгарсан эмэгтэйчүүдийг шагнаж урамшуулсан ба аймгийн “Засаг даргын жуух бичиг”-ээр 2, сумын “Засаг даргын жуух бичиг”-ээр 1, “Шилдэг бизнесмэн эмэгтэй”-ээр 3, аймгийн эмэгтэйчүүдийн холбооны “Хүндэт тэмдэг” – ээр 3, “Дурсгалын тэмдэг”-ээр 6 эмэгтэй шагнагдсан байна. Чуулганд оролцсон нийт эмэгтэйчүүдийн зүгээс “Дэлгэцийн донтолтын эсрэг” сэдвээр санал бодлоо солилцож сумын иргэддээ хандсан уриалгыг гаргаж, эмэгтэйчүүдээс гарсан санал хүсэлт, шийдвэрүүдийг нэгтгэн эрэмбэлж холбогдох удирдлагуудад хүргэн уламжилсан юм.

### **Баянгол сум:**

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны ажил улсын хэмжээнд явагдаж байгаатай холбогдуулан сумын Засаг даргын захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон ажиллаж, Өрхийн амжиргааны түвшин тогтоох судалгаатай холбогдуулан 147 өрхийг шинээр нэмж бүртгэн нийт 991 өрхийн мэдээллийн санг бүрдүүлж, зочлох өрхийн зураглал хийх ажиллагаа 84 хувьтай явагдаж байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс, сумын Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт салбар хороо,

Хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах сумын салбар хороо, Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг тус тус сумын Засаг даргын захирамжаар шинэчлэн байгууллаа.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр Мартын 8-ны баярыг угтаж Монголын эмэгтэйчүүдийн холбооны Баянгол суман дах салбар зөвлөл, сумын Ахмадын хороотой хамтран ахмадуудын дунд “Дуун цэнгүүн”-ийг зохион байгуулж, төрийн дээд шагнал одон медалиар шагнагдсан хүмүүст шагналыг гардуулан өгсөн. Мөн жил бүр зохион байгуулдаг “Ээжийн чанасан цай” арга хэмжээг амжилттай явуулж, уралдаанд 50 гаруй ээжүүд өөрсдийн гарын цайгаа нутаг нутгийн онцлогтоо тохируулан чанаж үзэгч олныг амтат цайгаараа дайлсан сайхан арга хэмжээ болж өнгөрсөн.

Монгол Улсад Зэвсэгт хүчин байгуулагдсаны 96 жилийн ойн баярт зориулан “Эх орон амгалан байг” дууны уралдааныг 2 төрлөөр зохион байгуулж 15 чөлөөт уран бүтээлчид, ардын авьяастнууд амжилттай оролцож 60 хүн хөгжөөн дэмжин үзэж сонирхсон байна.

Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн хоолны эрүүл ахуй, чанарт хяналт шалгалт хийх зорилгоор БДС, 21-р цэцэрлэг, Бүжинхэн цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл, ЭМТ-ийн дарга, НБМ нар үдийн цай хөтөлбөр, цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны чанар, хадгалалт, шинжилгээний бичигт хяналт шалгалт хийж ажиллалаа.

2017 оны 03 дугаар сарын 06-ны өдөр нийт 150 эцэг эхчүүдэд Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн түлэгдэлт эцэг эхийн хариуцлага сэдэвт сургалтыг зохион байгуулж иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэн ажиллалаа.

Сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын дунд “Бүтээмжийн 7 хоног” хөдөлгөөнийг өрнүүлж, “5С” зарчмыг ажилтан бүр үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

Сүрьеэтэй тэмцэх Дэлхийн өдөр 2017.03.24-ны өдрийг угтан 5 төр, төсвийн болон ААНБ-ын 168 ажилтан, албан хаагчид, багийн 46 иргэнд “Сүрьеэ эдгэрдэг өвчин” сургалтыг 8 удаа зохион байгуулсан. Мөн “Сүрьеэгүй ирээдүйн төлөө нэгдэцгээ” дэвжээ тэмцээн, марафон гүйлтийг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. ЗДТГ-тай хамтран “Сүрьеэгүй Сэлэнгэ” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Өсөх ирээдүйтэй бөх”-ийн барилдаан дунд ахлах бэлтгэл бүлгүүдийн дунд 2 насны ангиллаар зохион байгуулагдлаа. Барилдаанд 38 хүүхэд барилдаж ур чадвараараа өрсөлдлөө.

“Өвлөн бүжицгээ” монгол ардын бүжгийн тэмцээн бүлгүүдийн дунд зохион байгуулагдаж тэмцээнд 4 бүлгийн 32 хүүхэд оролцлоо.

“Сентеррагоулд Монголия”, “Эрдэнэс майнинг”, “Зенит норд стар фүүдс”, “Сэлэнгэ минериалс”, “Петровис” зэрэг аж ахуйн нэгж, байгуулга, 2 иргэнээс ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу ажил идэвхтэй хайгч иргэдээс зуучлах ажлыг зохион байгуулж 6 иргэнийг шинэ ажлын байранд, 5 иргэнийг сул чөлөөтэй ажлын байранд зуучилж нийт 11 иргэнийг байнгын ажлын байраар хангасан. Энэ сард ажилгүйдлийн бүртгэлд 35 ажил хайгч иргэн бүртгүүлсэн байна. 2017 онд хэрэгжих хөтөлбөрүүдийн талаархи мэдээллийг Хараа багийн хөдөөгийн хэсэгчилсэн иргэдийн Нийтийн Хурлын үеэр болон Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн самбар, Selenge aimag Bayangol sum фейсбүүк хаяг, ЗДТГ-ын гаднах электрон самбар зэрэг мэдээллийн хэрэгслээр танилцуулах, сурталчлах ажлыг хийсэн.

### **Орхонтуул сум:**

Сумын Засаг даргын Зөвлөлийн хурал энэ сарын 15-ны өдөр төлөвлөгөөний дагуу хуралдаж, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зарим ажлуудыг хэрэгжүүлж эхлэхээр “Соёлч өрх” шалгаруулах тухай, Худалдаа эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах тухай, Тариаланчдын зөвлөгөөн зохион байгуулах тов тогтоох тухай болон сумын эрүүгийн нөхцөл байдал,



цаашид анхаарах асуудлын талаар Хэсгийн төлөөлөгчийн мэдээлэл, Эрүүл мэндийн төвүүдийн ажлын мэдээлэл сонсч зөвлөмж өглөө.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 тоот тогтоолын дагуу сумын Онцгой комисс, Онцгой байдлын штабаас 03-р сарын 23-ны өдрийн 16 цагт Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага, сургуулийг сумын төв болон Рашаант тосгонд явууллаа. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн аврах, нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийг зохион байгуулж, сумын Засаг даргын захирамжаар томилгоожсон Мэргэжлийн ангийн Аврах бүлгийн Аврагчид, Сайн дурын бүлгийн идэвхтнүүд нийт 201 иргэн, ажилтан, албан хаагч оролцлоо.

Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 8 нэгж талбарын эзэмших эрх шилжүүлэх 6 хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэж, шинээр газар эзэмших хүсэлт гаргасан 5 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ.

Мал төллөлт, хаваржилтын байдал 03-р сарын 20-ны өдрийн байдлаар оны эхний малын 0,9% буюу 2117 толгой мал хорогдсноос адуу-113, үхэр-274, хонь-958, ямаа-772, үүнээс өвчнөөр 105 толгой мал хорогдсон байна. Мал төллөлт төл бойжилт одоогийн байдлаар төллөх 96290 хээлтэгчийн 13,2% буюу 12764 толгой хээлтэгч мал төллөж гарсан төлийн 98,9 % буюу 12626 толгой төл бойжиж байна.

### **Шаамар сум:**

Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан сумын эрүүл мэндийн төвөөс гар бөмбөг, аэробекийн тэмцээнийг, орчин цагийн Зэвсэгт хүчний 96 жилийн ойн баярыг тохиолдуулан “Би Монгол эр хүн” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж гар бөмбөг, хийн буудлага, ширээний теннисийн тэмцээнийг явууллаа.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиог дуугаргаж, иргэд олон нийт, аж ахуйн нэгж байгууллагууд идэвхитэй оролцож газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах арга хэмжээг зохион байгуулсан.

### **Хүдэр сум:**

Дархан-уул аймагт зохион байгуулсан “Удирдах ажилтаны зөвлөлдөх уулзалт”-тус сумын уул уурхай, газар тариалан, мод модон материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 23 аж ахуйн нэгжид урилга хүргүүлсэнээс 14 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцлоо. Орон нутгаас сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, багийн Засаг дарга нар, БОХУБайцаагч, Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлөөс тус тус оролцлоо.Уулзалтаас энэ онд орон нутагт хийх хөрөнгө оруулалт, бүтээлч ажлыг танилцуулан аж ахуйн нэгжийн удирдлагуудтай өөрсдийн дотоод нөөц бололцоо, санхүүгийн эх үүсвэр дээр тулгуурлан хийх ажлын талаар санал бодлоо солилцсоны үр дүнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэхээр тохиролцон гэрээ байгуулав.

Сумын “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийгшинэчлэн сумын Засаг даргын 2017 оны А/37 дугаар захирамжаар баталгаажуулсан. Мөн сумын “Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт салбар хороо”-г шинэчлэн сумын Засаг даргын 2017 оны А/38 тоот захирамжаар батлагдсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлж байгаа Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тавигдах шаардлагыг хангасан 10 малчин өрхийг, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөртМэргэжил сургалт үйлдвэрийн төв төгссөн 15-24 насны хувиараа бизнес эрхлэх хүсэлтэй 7 иргэнийг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих төсөл хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хүүхдээ асарч байгаа эцэг эхэд олгох төсөл хөтөлбөрт 10 иргэнийг хамруулахаар тус тус бүртгэж авсан байна.

2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэж байгаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд сумдын “Хүүхэд гэр бүл хамгааллын хамтарсан баг”-ийг сумын Засаг даргын 2017 оны А/41 дүгээр захирамжаар, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор “Хүүхдийн төлөө зөвлөлийг байгуулах тухай” сумын Засаг даргы 2017 оны А/40 дүгээр захирамж гаргасан.

### **Сүхбаатар сум:**

Сумын Засаг дарга Т.Гантулга 8 багийн иргэдтэй уулзан бүрэн эрхийнхээ хүрээнд хийх ажлынхаа талаар мэдээллийг танилцуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч боломжтой зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллалаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын сургалтын орчин, MNS 6558-2015 сатндартын хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийх үүднээс 3 цэцэрлэгт шалгалт хийхэд стандарт хангалт 80 хувьтай буюу шаардлагад нийцсэн гэсэн дүгнэлт гарсан.

“Халуун сэтгэл-Хамтын хүч” уриан дор малчдад зориулсан сайн үйлсийн аяны хүрээнд нийт 803000 төгрөгийн үнэ бүхий эд зүйл цугларсныг Хонгор морьтын 1 дүгээр баг, Бор гүвээний 5 дугаар багийн мал бүхий иргэдэд хуваарилан олголоо

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн 2017 оны 1/119 тоот албан бичгийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа 12 талх, нарийн боовны цехүүдэд үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүний жин хэмжээ, хаяг шошго, савлалтанд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

### **Хушаат сум:**

Олон Улсын Улаан Загалмайн Хороо, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооноос МУЗН-тэй хамтран зохион байгуулж буй "Бэлэн мөнгөн сан тусламж"-ийн хөтөлбөрийн хүрээнд Хушаат сумаас төсөл хэрэгжүүлэгчдийн тавьсан шаардлагын дагуу малын тоо /хонин толгойд шилжүүлснээр 200-с доош малтай, 6-аас дээш ам бүлтэй, ганц бие, өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэх мэт шалгуур үзүүлэлтийг хангасан 19 малчин өрх тус бүр 245.000 төгрөгийн бэлэн мөнгөний тусламжийг олголоо.

Хушаат сумын Эмэгтэйчүүдийн холбооноос "Өргөмжлөлт ээжүүдийг алдаршуулах ёслолын ажиллагаа", Монгол цэргийн баярын арга хэмжээний хүрээнд сумын "Хан Хушаат" бөхийн холбооноос зориулан хүчит 32 бөхийн барилдаан, "Би эр хүн" тэмцээнийг тус тус зохион байгууллаа.

Татварын орлогын төлөвлөгөө 14499.0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 17701,0 төгрөг буюу 122%-ийн биелэлттэй байна. Үүнээс Хушаат төрийн сан 4159,2 төгрөг төлөвлөгдсөнөөс 300.0 төгрөг буюу 1,3%, аймгийн төрийн санд 8475.0 төгрөг төлөвлөгдсөнөөс 6556,0 буюу 77%, Улсын төвлөрсөн санд 1865,6 төгрөг төлөвлөгдсөнөөс 10845.0 төгрөг буюу 581%-ийн биелэлттэй байна. Буутай болон Сэ дугаартай автомашинтай иргэдийн судалгааг гарган Да, УБ дугаартай болон бусад аймгийн номертой автомашин эзэмшигчдийн судалгааг гарганхувийн хэрэг нээж байна. 2016 оны ХХОАТатварын дутуу төлөлт ЭМТөв 1752.2 мян.төгрөг, сургууль 845.4, цэцэрлэг 102,2, ЗДТГ 533.0 нийт 3233.000 төгрөгийг барагдууллаа.

3-р сарын 21-ний байдлаар Нийгмийн даатгалын шимтгэлд 17 байгууллага, аж ахуйн нэгжийн 29743.5 мянган төгрөгний, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 76 хүний 6009.7 мянган төгрөгний шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 63 хүний 1639.7 мянган төгрөгний хураамжуудыг тус тус дансанд оруулсан. Шинээр тэтгэвэр тогтоолгох 5 хүний материалын баталгаажуулж тэтгэвэр тогтоолгох зөвлөгөөг 12 хүнд өгч, ЭМД, НД, сайн дурын даатгалд даатгуулах зөвлөгөөг 75 хүнд хүргэн үйлчиллээ.

Үдийн цайны хөтөлбөрийн хэрэгжилт дээр үндэслэн “Миний ээж ажилсаг” 1-5-р ангийн ээжүүдийн дунд гарын доорх материал ашиглан хүүхдэд эрүүл зөв хоол бэлтгэх талаар өдөрлөг зохион байгуулсан. Мөн “Охидын шивнээ” “Бүгдээрээ ярилцъя” ярилцлага 6-11 ангийн охид, хөвгүүдэд ЭМТ-тэй хамтарч сургалт зохион байгуулснаас гадна “Завсарлагааны дэг журмыг хэвшүүлэх сарын аян” –ыг эхлүүлж, сургуулийн коридор, анги танхимдаа гүйхгүй, хашгирахгүй, ноцолдохгүй байж, аядуу зөөлөн дуугарч байгаад ажиглалт хийж, зөрчил гаргаж байгаа сурагчидад шаардлага тавих, мөн их завсарлагаанаас бусад завсарлагаанаар хүүхдийг ангиас гаргахгүй байж, дараачийн хичээлийн бэлтгэлийг хангуулах хэвшилд суралцах дадлага хийлгэсэн.

Сумын байгаль хамгаалагч нар хөдөөгийн 2 багийн нийт 52 өрхийн 86 иргэнийг хамруулан байгаль орчныг хамгаалах талаар яриа таниулга хийн малын сэг зэмийг цуглуулан нэг цэгт бөөгнүүлж ариутгал устгал хийх талаар үүрэг даалгаварыг өглөө.1-р улирлын байдлаар 20 иргэнд гоожингийн эрхийн бичиг бичигдэн 139875 төгрөгийг төсөвт оруулсан байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР